ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 07 өдөр Дугаар 06/23 Сайншанд

Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын
зөвлөлийн үйл ажиллагааг үнэлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 зүйлийн 64.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын зөвлөлийг 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлыг хянах үйл ажиллагааг “Хангалттай сайн” хэрэгжүүлэн ажилласан гэж үнэлсүгэй.

2. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг цаашид улам сайжруулан ажиллахыг зөвлөлийн даргад, зөвлөлийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн шаардлагатай шатахуун, бичиг хэргийн зардлаар хангаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ш.Одмаа)-д зөвлөсүгэй.

ДАРГА Ч.ОГТБИШ

142